



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ЗАА-2025/27-12-ШТА-ГА

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН 2023-2024 ОНД НОГДУУЛСАН 383.6 САЯ
ТӨГРӨГИЙН ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ, ОРЛОГЫН
БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫН СИСТЕМ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

**Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа**

Утас: 704623612 цахим хуудас: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар

Утас: 70463783 цахим хуудас: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Заяа

Утас: 90088028 цахим хуудас: zayag@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхнасан

Утас: 90066888 цахим хуудас: munkhnasanb@audit.gov.mn

Аудитор Н.Цогтсайхан

Утас: 99125745 цахим хуудас: tsogtsaikhann@audit.gov.mn

Аудитор Г.Нармандах

Утас: 99031794 цахим хуудас: narmandakhg@audit.gov.mn

Улиастай хот 2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГ	3
АУДИТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
А. А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....	5-10
Б. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРҮҮЛЖ, ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.....	10-14
В: ТОРГУУЛИЙН ОРЛОГООС ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААРИЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	14-16
Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА	16-20
ДҮГНЭЛТ	21-22
ЗӨВЛӨМЖ:	23-24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	25-26



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/28

Улиастай

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт,
зарцуулалт сэдэвт аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт болон холбогдох бусад газруудад хүргүүлэхийг шинжээч (У.Хорлоо)-д, нээлттэй аудит цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах болон аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Г.Заяа)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.


Д.БАТ-УНДРАА

812501044

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	5
Хүснэгт 2	Аймгийн торгуулийн орлогын задаргаа	6
Хүснэгт 3	Санхүүгийн тайланд тусгагдсан хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	10
Хүснэгт 4	Торгуулийн орлогын гүйцэтгэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын хуваарилалт	12
Хүснэгт 5	Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн хуваарилалт	13
Хүснэгт 6	Торгуулийн орлогыг төлбөрийн системээр дамжуулан төлсөн мэдээлэл/ тоогоор/	16
Хүснэгт 7	Торгуулийн орлогыг барагдуулахдаа шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан байдал	17

Зураглалын жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	Зураглал №1 Хүү, торгуулийн орлогын татварын орлогод эзлэх хувь	11

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, МУЕА-ын 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: А. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх; Б. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх; В: Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх; Г.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын тайлан, судалгаа, 2023, 2024 онд аймгийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн хүү, торгуулийн орлого, түүний зарцуулалт, хяналт хэрэгжүүлсэн талаарх тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Монгол улсын Ерөнхий аудиторов А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулсан. Нотлох баримтыг нягтлан шалгахдаа дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглалаа.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Г.Нармандах, Н.Цогтсайхан, Б.Мөнхнасан нар 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2025 оны 07 дугаар сарын 28-ны хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын ерөнхий мэдээлэл

Завхан аймагт зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий 195 ажилтан 17 байгууллагад ажиллаж байна. 2023, 2024 онуудад 58,029 зөрчилд 2,054.7 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 81.3 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Аймгийн төсвийн орлогод 2023 онд 1,480.9 сая төгрөгийн, 2024 онд 1,164.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 2023 онд 1,143.2 сая төгрөг, 2024 онд 1,484.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Торгуулийн орлогын тодорхой хэсгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон замын санд төлөвлөн, зарцуулах хуулийн зохицуулалттай. Үүний дагуу аймаг, сумдын ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 221.4 сая, 2024 онд 297.5 сая төгрөгийг баталсан байна.



А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.**А.1. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ НЬ БОДИТ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН,ХАРИН ХҮҮГИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХ ЭХ ҮҮСВЭРГҮЙ, ТООЦОХОД ХҮНДРЭЛТЭЙ БАЙНА.**

А.1.1. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хүүгийн орлого төвлөрүүлэх эх үүсвэр байхгүй байгаа тул 2023-2024 онд тус орлогыг төлөвлөөгүй байна.

Сумдын Засаг дарга нар Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг тухайн жилд зээлдэгч нарын зээлийн гэрээний дагуу төлөх үндсэн зээл, хүүгийн хэмжээгээр, сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөж, сумдын ИТХ-аар баталсан байна. Тухайлбал: Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг тусад нь салгаж төлөвлөдөггүй, тухайн жилд төлөгдөх зээл, хүүгийн эргэн төлөлтийн нийт дүнгээр баталсан байна.

А.1.2. Торгуулийн орлогыг төлөвлөснөөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1¹, “Авто замын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4²-д заасны дагуу орлогын тодорхой хувийг зориулалтын дагуу төлөвлөж, зарцуулах нөхцөл бүрдэж байгаа тул бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Аймгийн орон нутгийн төсөвт торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төлөвлөгөөний дагуу аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолуудаар тодотгон 2023 онд 1,480.9 сая, 2024 онд 1,164.6 сая төгрөгөөр төлөвлөн баталжээ.

А.2. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН, ТӨЛӨВЛӨЖЭЭ.

А.2.1. Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр судалбал 2022, 2024 онд торгуулийн орлого 124-127 хувиар давж биелсэн бол 2023 онд 23.0 хувиар дутуу биелсэн байна.

Хүснэгт №1 Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая. төгрөг/

Үзүүлэлт	2022 оны Төлөвлөгөө	2022 оны Гүйцэтгэл	2023 оны Төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	2024 оны Төлөвлөгөө	2024 оны Гүйцэтгэл
А	1	2	3	4		
Торгуулийн орлого	800.0	994.4	1,480.9	1,140.8	1,164.6	1,481.4

¹ торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

² замын сангийн эх үүсвэрт нийцлэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

А.2.2. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөн, Сангийн яам жил өмнөх оны гүйцэтгэлээс нэмэгдүүлэн хянасан байна.

А.2.3. Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөөгүй байна.

Сумдын Засаг дарга нар Хоршоо хөгжүүлэх сангаас олгогдож буй хөнгөлөлтэй зээлийн хүүгийн орлогыг салгаж төлөвлөөгүй байна.

А.2.4. Торгуулийн орлогоос аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 153.0 сая төгрөгийг, 2024 онд 230.9 сая төгрөгийг үйл ажиллагаанд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т заасны дагуу зарцуулахаар төлөвлөсөн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 11 сумын Засаг дарга 2023 онд 68.4 сая төгрөгийг, 9 сумын Засаг дарга 2024 онд 66.6 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн авто замын сангийн үйл ажиллагаанд “Авто замын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4³-д заасны дагуу зарцуулахаар зардал төлөвлөөгүй бол сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зээлийн хүүгийн орлогыг тухайн сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас дараа онд олгох зээлийн эх үүсвэрийн нэг хэсэг болгон төлөвлөж байна.

А.2.5. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэдэггүй, торгуулийн орлогын төлөвлөлтийг хийхдээ өмнөх жилүүдийн гүйцэтгэл, тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэл зэргийг харьцуулан судалж, суурь мэдээлэл болгон ашигладаг байна.

А.2.6. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь 2023, 2024 онуудад торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолоогүй байна.

Хүснэгт №2. Аймгийн торгуулийн орлогын задаргаа/ сая. төгрөг/

	2023 он төлөвлөгөө	2023 он гүйцэтгэл	Хувь	2024 он төлөвлөгөө	2024 он гүйцэтгэл	Хувь
Татварын хэлтэс	98.9	138.8	140.3	151.0	474.6	314.3
Сумдын Засаг дарга	471.8	420.4	89.1	330.0	548.8	166.3
Аймгийн Засаг дарга	910.2	581.6	63.9	834.6	458.0	54.9
Нийт	1,480.9	1,140.8	77.0	1,164.6	1,481.4	127.2

³ замын сангийн эх үүсвэрт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

Татварын алданги, торгуулийн орлогын эх үүсвэрийг 2023 онд үндэслэлтэй төлөвлөсөн бол 2024 онд өмнөх онуудын татварын алданги торгуулийн өрийг 90 хувиар барагдуулсантай холбоотойгоор давж биелсэн байна.

Аймгийн Цагдаагийн байгууллага нь 2023 онд 607.9 сая төгрөгийн, 2024 онд 744.4 сая төгрөгийн торгуулийн орлого бүрдүүлсэн нь орон нутгийн төсөвт төвлөрсөн нийт торгуулийн орлогын 50.1-53.2 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Торгуулийн орлогын 17.9-34.7 хувийг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 7 байгууллагын 34 албан тушаалтан төвлөрүүлж, 10 байгууллагын 72 албан тушаалтан тайлант хугацаанд торгуулийн орлого огт ногдуулаагүй байна. Эдгээр эрх бүхий 72 албан тушаалтнуудын зарим нь торгууль ногдуулахгүйгээр зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн боловч биелэлтийг бодитой тооцож, баримтжуулаагүй, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байхад дараагийн шатны арга хэмжээг аваагүй, зарим эрх бүхий албан тушаалтнууд нь салбарын зөрчлийг арилгах, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлдэггүй зөрчил илэрлээ

Эндээс аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийг 2023, 2024 онуудад торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолоогүй, торгуулийн орлого бүрдүүлдэг эрх бүхий байгууллагуудын ногдуулалт, гүйцэтгэлийг хянаж, дүн шинжилгээ хийгээгүй байна гэж дүгнэлээ. Цаашид эрх бүхий албан тушаалтнуудад Зөрчлийн тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах талаар нэгдсэн сургалт зохион байгуулах шаардлагатай байна.

А.3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО ХОЛБОГДОХ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГАД НИЙЦСЭН БАЙНА.

А.3.1. Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар торгуулийн орлогын бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байна.

- ✓ Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино” гэж заасан нь Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа бүхий л хуулийн хүрээнд шийтгэл ногдуулах арга хэмжээг нэгтгэн зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, торгууль ногдуулах эрх бүхий байгууллагуудын торгуулийн хувь хэмжээг энэ хуулиар зохицуулжээ.
- ✓ Торгох шийтгэлээр шийтгэгдсэн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй хэдий ч үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн доорх уян хатан нөхцлийг шинээр бий болгосон байна. Тухайлбал: зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлэх үндэслэл нь

торгуулийн орлогын бүрдүүлэлт, бодит хэрэгцээ шаардлагад эерэг нөлөөг үзүүлж байна.

- ✓ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д “Зөрчил шалган шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”, 1.3 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана”, 1.8 дугаар зүйлийн 1-д “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна” 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ”, 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж тус тус заасны дагуу аймгийн хэмжээнд торгуулийн орлого бүрдүүлдэг 17 байгууллагын 119 торгох эрх бүхий албан тушаалтнууд Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүдийг шалган шийдвэрлэж байна.

А.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан байна.

- ✓ Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно”, Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09 ний өдрийн хамтарсан А-7/08/04 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох” тухай тушаалын 1-д “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасны дагуу төсөвт байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэлд хүү тооцуулах боломжтой байна.
- ✓ Төв банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Монгол банк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах арга, хэрэгслийг ашиглаж болно”, 1.3-д “Хүүгийн нэгдсэн бодлого явуулах”, 14 дүгээр зүйлд “Монгол банк нь өөрийн зээл, үнэт цаасны хүү болон хямдруулалтын хувиар дамжуулан банкны хүүгийн нэгдсэн бодлого явуулна”, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-аар хүү бодох аргачлалыг тодорхой тусгаж өгсөн байна.

А.3.3. Торгуулийн орлогын бүрдүүлэлтэд дараах хууль журмын заалтууд сөргөөр нөлөөлж байна.

- ✓ Монгол Улсын Ерөнхий Прокурор, ХЗДХС-ын хамтарсан 2024 оны А/42, А/71 дугаар тушаалаар баталсан “Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан

торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох, хугацаа, аргачлал” журмын 2.5-д зааснаар, торгууль төлөөгүй этгээдийн оршин суугаа газрын харьяа шүүхэд хандах үүргийг шийтгэл оногдуулсан албан хаагч хүлээдэг нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж, торгууль төлүүлэхэд хугацаа алдах, зардал нэмэгдэх зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

- ✓ Захиргааны ерөнхий хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1.1-д “Захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага гүйцэтгэнэ”, 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт “Захиргааны шийдвэрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд захиргааны байгууллага хуульд заасан журмын дагуу албадлага хэрэглэнэ” гэж заасан боловч захиргааны акт гаргасан торгох эрх бүхий албан тушаалтан ямар журмаар торгуулийн актыг барагдуулах, албадлагын арга хэмжээг хэрхэн явуулах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа нь торгуулийн орлого бүрэн төлөгдөхгүй байх нэг шалтгаан болж байна.

А.3.4. Тайлант хугацаанд 195 эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан 2,053.7 сая төгрөгийн торгуулийн орлогын үндэслэлийг түүвэрлэн шалгахад торгуулийн хэмжээ болон торгосон үндэслэл нь Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалттай нийцэж, зөрчлийн шинжид тохирсон байна.

А.3.5. Иргэн, хуулийн этгээдэд ногдуулсан торгууль, шийтгэлийн эрх зүйн үндэслэл нь Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдаж, иргэн, хуулийн этгээдийн үйлдсэн зөрчилд торгууль ногдуулахаар тусгагдсан байна. Тус хуульд зөрчлийн хэлбэрээс нь шалтгаалан иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх заалт байхгүй учир хууль хэрэглээ нь бүх нийтэд тэгш үйлчилж байна.

А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.

- ✓ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, 23.9.3-т “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: хууль тогтоомжийн дагуу сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт орох бусад орлого” гэж заасныг зөрчин Монгол банкны салбар, Гаалийн хороо, аймгийн Эрүүл мэндийн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Боловсролын газар зэрэг 8 байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд зөрчин ногдуулсан торгуулийн орлогоо улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.
- ✓ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэгт заасны дагуу торгуулийн орлогоос хуваарилагдсан хөрөнгө нь аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Прокурорын газар, Шүүхийн Тамгын Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх газар, аймгийн Боловсролын газар зэрэг цөөхөн байгууллагын хүрээнд зөвхөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд түлхүү зарцуулагдаж байна. Орон нутагт ажиллаж байгаа бусад эрх бүхий албан хаагчдын ажиллах нөхцөлийг

сайжруулахад энэ зардлаас хуваарилдаггүй, урамшууллын тогтолцоогүй байдал нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

А.3.7. Зөрчлийн тухай хуулийн хүрээнд ногдуулсан торгуулийг заасан хугацаанд төлөөгүйгээс Шүүхийн шийдвэр гарч шийдвэрлэгдсэн тохиолдолд иргэний өмчид халдсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Б. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРҮҮЛЖ, ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

Б.1. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ТӨСӨВТ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

Б.1.1. Тайлант хугацаанд 383.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 13 байгууллагын эрх бүхий 195 албан тушаалтан 2023 онд 28,903 зөрчилд 925.9 сая төгрөгийн, 2024 онд 29,126 зөрчилд 1,128.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Гүйцэтгэлээр 2023 онд 760.9 сая төгрөгийн, 2024 онд 910.2 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлэн, 383.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Цагдаагийн газар 2023 онд торгуулийн орлогыг 139.3 сая төгрөгөөр, 2024 онд торгуулийн орлогыг 191.6 сая төгрөгөөр хэрэгжүүлээгүй;
- Хилийн цэргийн 0277 дугаар анги 2023 онд торгуулийн орлогыг 0.9 сая төгрөгөөр, 2024 онд торгуулийн орлогыг 0.1 сая төгрөгөөр хэрэгжүүлээгүй;
- Байгаль орчны газар 2024 онд торгуулийн орлогыг 0.1 сая төгрөгөөр хэрэгжүүлээгүй;
- Татварын газар 2023 онд торгуулийн орлогыг 24.8 сая төгрөгөөр, 2024 онд торгуулийн орлогыг 26.8 сая төгрөгөөр хэрэгжүүлээгүй байна.

Б.1.2. Торгуулийг 13 байгууллагын эрх бүхий 195 албан тушаалтан тавьсан байна.

Б.1.3. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үнэн зөв тусгаагүй байна.

Хүснэгт №3. Санхүүгийн тайланд тусгагдсан хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/


Үзүүлэлт	2023 оны Төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	2024 оны Төлөвлөгөө	2024 оны Гүйцэтгэл
А	1	2	3	4
Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн орлого		78.5		80.3
Бусад орлого / Хоршоо хөгжүүлэх сангийн хүү/		189.1		231.9
Хадгаламжийн хүүгийн орлого /Хөрөнгийн татвар/	1,100.0	1,212.1	1,066.9	2,012.9
Дүн		1,290.6		2,093.2

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Засаг даргын 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан 3,225.0 сая төгрөгийн татварын орлогыг хүүгийн орлогоор тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3-д “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам-ын 4.7.3-д “Орон нутгийн төсвийн орлогыг орлогын нэр төрөл болон орлого төвлөрүүлэгч байгууллагаар тооцоо нийлж баталгаажуулан санхүүжилт олгох ерөнхий орлогын дансанд ангилан бүртгэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
- 2023-2024 онд 13 сумын Засаг дарга Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүү 158.8 сая төгрөгийг хүү торгуулийн орлогоор, 11 сумын Засаг дарга Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүү 421.0 сая төгрөгийг бусад орлогоор тайлагнасан байгаа нь хүүгийн орлогын дүнг тулган, дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулж, Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3-д “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх” гэснийг зөрчсөн байна.
- Аймгийн Онцгой байдлын газар нь зураг төсөв хянасны болон галын дүгнэлт гаргасны үйлчилгээний төлбөрийн 2.4 сая төгрөгийг 2023 онд, 3.0 сая төгрөгийг 2024 онд торгуулийн орлогын дансанд төвлөрүүлснийг аймгийн Төрийн сан хяналгүйгээр торгуулийн орлогын гүйцэтгэлийг буруу тайлагнасан байна.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь орон нутгийн татварын орлогын бүрэлдэхүүнд нөлөө багатай 5.4-6.2 хувийг эзэлж байна.

Зураг №1. Хүү, торгуулийн орлогын татварын орлогод эзлэх хувь, /сая төгрөг/



Б.2. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

Б.2.1. Тайлант хугацаанд аймгийн болон 14 сумын ИТХ нь хүү торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 221.4 сая төгрөгийг, 2024 онд 297.5 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аудитын илрүүлэлт:

- 2023 онд Алдархаан, Цагаанхайрхан сумдын ИТХ, 2024 онд Асгат, Баянхайрхан, Тэлмэн, Эрдэнэхайрхан сумдын ИТХ нь хүү торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд хөрөнгө хуваарилаагүй байна.
- Баянтэс, Дөрвөлжин, Завханмандал, Нөмрөг, Отгон, Түдэвтэй, Улиастай, Сантмаргац, Цэцэн-Уул, Шилүүстэй, Яруу зэрэг сумдын ИТХ нь хүү торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд хөрөнгө огт хуваарилж төлөвлөөгүй байна.

Б.2.2. Аймгийн болон 14 сумын ИТХ торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилахдаа өмнөх жилийн торгуулийн орлогын гүйцэтгэлийг харгалзаагүй, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Хүснэгт №4. Торгуулийн орлогын гүйцэтгэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын хуваарилалт, /сая төгрөг/

ГХУСАЗСЗ байрлах сумын нэр	2023 оны Торгуулийн орлогын Гүйцэтгэл	Аймаг, сумдын ГХУСАХ-д хуваарилсан хөрөнгө	Хувь хэмжээ	2024 оны Торгуулийн орлогын Гүйцэтгэл	Аймаг, сумдын ГХУСАХ-д хуваарилсан хөрөнгө	Хувь хэмжээ
Аймаг	722.90	153.00	21%.	935.60	230.90	25%.
Алдархаан				0.30	1.00	0.3%.
Асгат	9.10	3.50	38%.	2.40	-	-
Баянтэс	4.90			1.70	-	-
Баянхайрхан	3.30	2.20	66%.	0.50	-	-
Дөрвөлжин	6.80			2.20	-	-
Завханмандал	2.40			0.80	-	-
Идэр	2.40	3.50	145%.	0.60	2.00	333%.
Их Уул	57.40	1.50	3%.	79.90	1.50	2%.
Нөмрөг	24.50			52.90	-	-
Отгон	6.00			0.80	-	-
Сантмаргац	4.20			2.00	-	-
Сонгино	44.20	2.00	4%.	61.80	2.00	3.2%.
Тосонцэнгэл	203.70	19.00	9%.	274.30	27.00	9.8%.
Түдэвтэй	3.70			1.00	-	-
Тэлмэн	26.00	6.00	23%.	48.70	-	-

Тэс	5.50	15.00	272%.	2.90	17.80	635%.
Улиастай	7.80			10.10	-	-
Ургамал	3.20	10.00	322%.	1.50	10.00	666%.
Цагаанхайрхан	0.70			0.80	4.50	642%.
Цагаанчулуут	1.60	3.60	225%.	0.50	0.80	160%.
Цэцэн-Уул	1.50			0.20	-	-
Шилүүстэй	0.80			2.10	-	-
Эрдэнэхайрхан	0.60	2.00	333%.	0.50	-	-
Яруу	-	-		0.30	-	-
Нийт дүн	1,143.20	221.30	19.40	1,484.40	297.50	20.0

Дээрх хүснэгтээс харахад тайлант хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд хуваарилсан хувь хэмжээ нь торгуулийн орлогын 20 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл хуульд заасан хувь хэмжээнээс 2 дахин бага дүнгээр төлөвлөн тусгасан байна.

Аудитын илрүүлэлт:

- 2023 онд Баянхайрхан, Идэр, Тэс, Ургамал, Цагаанчулуут, Эрдэнэхайрхан зэрэг сумдын ИТХ нь өмнөх жилийн торгуулийн орлогын гүйцэтгэлээс 66-333 хувиар нэмэгдүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилсан.
- 2024 онд Идэр, Тэс, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут зэрэг зэрэг сумдын ИТХ нь өмнөх жилийн торгуулийн орлогын гүйцэтгэлээс 160-666 хувиар нэмэгдүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилсан.
- Аймгийн Цагдаагийн газраас 2023 онд 28,525 зөрчилд 612.1 сая төгрөгийн, 2024 онд 28,693 зөрчилд 748.3 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлсэн боловч Замын сангийн эх үүсвэрт хуваарилагдаагүй байгаа нь Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ: нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль” гэж заасныг зөрчсөн байна.

Б.2.3. Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зориулалтын дагуу хуваарилсан, сумдын ГХУСАЗСЗ нь тайлант хугацааны зардлын хуваарилалт, төлөвлөгөө, тайланг Аймгийн ГХУСАЗСЗ-д ирүүлээгүй тул дүгнэх боломжгүй байна.

Хүснэгт №5. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн хуваарилалт, /сая төгрөг/

Он	Тоног төхөөрөмж	Нийт зардалд эзлэх хувь	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Нийт зардалд эзлэх хувь
2023	54.5	35.6%	98.5	64.4%
2024	83.1	35.9%	146.9	63.6%
Нийт	106.1		276.9	

Сумдын ГХУСАЗСЗ тайлант хугацааны зардлын хуваарилалт, төлөвлөгөө, тайланг Аймгийн ГХУСАЗСЗ-д ирүүлээгүй зөрчил илэрлээ.

Б.2.4. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдад торгуулийн орлогын төлөвлөгөө өгдөггүй, төвлөрүүлсэн торгуулийн орлогын хэмжээг албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд харгалзаж үздэггүй байна.

Хэрэв шалгуур үзүүлэлтэд хамруулж үзвэл байгууллагын зорилго алдагдах, хэт их торгууль тавих сэдлийг төрүүлэх, иргэдийн амьдралд дарамт учруулах, тэдний итгэлийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох магадлалтай байна.

БҮЛЭГ В: ТОРГУУЛИЙН ОРЛОГООС ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААРИЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

В.1. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1.1. Аймгийн ГХУСАЗСЗ нь тайлант хугацаанд нийт хуваарилагдсан хөрөнгийн 97.7 хувийг зориулалтын дагуу зарцуулсан, сумдын ГХУСАЗСЗ тайлан мэдээгээ ирүүлээгүй тул тодорхойлох боломжгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумдын ГХУСАЗСЗ нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тайлан мэдээ ирүүлээгүй.
- 2024 онд эрүүлжүүлэх байрны сургалтын өрөөний засвар хийх ажлыг төлөвлөж 9.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.5 дахь заалтад тусгагдаагүй зардлыг төсвөөс санхүүжүүлсэн байна.

В.1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсөв нь аймгийн ИТХ-ын төсвийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж (210801) зардлын дансанд хуваарилагдан зарцуулагдсан бөгөөд эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэгдэн зарцуулагдаагүй байна.

В.1.3. Аймгийн ГХУСАЗСЗ нь 2023 онд 4 бүлэгт хамаарах 63 арга хэмжээнд 153.0 сая төгрөгийг, 2024 онд 4 бүлэг, 74 арга хэмжээнд 230.9 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Тайлант онуудын аймгийн ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөө, тайлангаас үзэхэд 2023 онд 27 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 15,000 гаруй иргэн, 2024 онд 34 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 19,000 гаруй иргэн хамрагдсан байна. Тайлант хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоог аймгийн нийт хүн амтай харьцуулахад хамрагдалтын хувь хэмжээ хангалттай бус байна.

В.1.4. Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэрэг, зөрчлийн суурь шалтгаан, нөхцөлийг тогтоож, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулан, таслан зогсоох чиглэлээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд нийгэм, эдийн засагт эерэг үр дүн гарсан байна.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхцөл байдал дараах байдлаар буурчээ.

Гэмт хэрэг: 2023 онд 328 гэмт хэрэг бүртгэгдсэн ба гэмт хэргийн тоог 2022 онтой харьцуулахад 77 нэгжээр буюу 19 хувиар буурсан байна. 2024 онд 285 гэмт хэрэг бүртгэгдсэн ба гэмт хэргийн тоог 2023 онтой харьцуулахад 43 нэгжээр буюу 13.1 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн хохирол: 2023 онд 1,899.2 сая төгрөгийн хохирол бүртгэгдсэн ба 2022 онтой харьцуулахад 795.3 сая төгрөгөөр буюу 29.5 хувиар буурсан байна. 2024 онд 1,765.7 сая төгрөгийн хохирол бүртгэгдсэн ба 2023 онтой харьцуулахад 133.5 сая төгрөгөөр буюу 7 хувиар буурчээ.

В.2. ТОРГУУЛИЙН ОРЛОГООС ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ШИЛЭН ДАНСАНД БҮРЭН МЭДЭЭЛСЭН БОЛОВЧ ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮН, ТАЙЛАНГ НЭГТГЭЖ ИРГЭД ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙНА.

В.2.1. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2023 онд санхүүжүүлсэн 43.2 сая төгрөгийн 4 гүйлгээ, 2024 онд санхүүжүүлсэн 149.9 сая төгрөгийн 16 гүйлгээг шилэн дансны цахим системд бүрэн байршуулсан байна.

В.2.2. Аймгийн ГХУСАЗЗөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын мэдээ, мэдээллийг өөрсдийн цахим хаяг (фэйсбүүк), www.zavkhan.khural.mn сайтад байршуулан олон нийтийг мэдээллээр хангаж байна. Харин хүү торгуулийн орлогын зарцуулалтын үр дүн, тайланг нэгтгэж иргэд олон нийтэд хүргэсэн ажлын баримт материал байхгүй байна.

В.2.3. “Оюунлаг таны туслагч” ТББ нь аймгийн ИТХ-ын 2023 оны 1-3 дугаар улирлын шилэн дансны цахим системд 1 удаа хяналт шалгалтыг хийснээс өөрөөр иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Г.1. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙХГҮЙ БАЙНА.

Г.1.1. Байгууллага хооронд торгуулийн орлогын мэдээллийн нэгдсэн сан бий болоогүй доорх байгууллагууд салбарынхаа цахим системийг ашиглаж байна.

- ✓ Цагдаагийн газар нь Зөрчлийн хэрэг бүртгэлийн нэгдсэн санд торгуулийн төлбөрийг барагдуулсан эсэх талаар тийм/үгүй гэсэн тэмдэглэл хийж бүртгэдэг.
- ✓ Татварын газар нь Tais системээр татварын орлогыг бүртгэж, ТЕГ-ын Татвар хураалтын удирдлагын газар нь нэгдсэн сан үүсгэдэг.

Г.1.2. Аймгийн хэмжээнд торгууль ноогдуулдаг эрх бүхий 17 байгууллага байгаагаас зөвхөн цагдаагийн байгууллага торгуулийн төлбөрийн системийг бүрэн ашиглаж байна.

Аймгийн Цагдаагийн газар нь “Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн систем”-ээр торгуулийн орлого, зөрчлийн бүртгэлээ бүртгэдэг бөгөөд Замын цагдаагийн албан хаагчид бэлэн бусаар торгууль ногдуулахдаа шалгах багажийн (x-cover) тусламжтайгаар “E-Patrol” аппликейшныг ашигладаг. Тус аппликейшн нь тухайн орон нутгийн төрийн сангийн данстай шууд холбогдсон байна.

Аймгийн Цагдаагийн газраас ногдуулсан торгуулийг иргэн, хуулийн этгээд дараах төлбөрийн шийдлүүдийг ашиглан төлөх боломжтой байна. Үүнд:

- ✓ E-mongolia.mn цахим хуудас.
- ✓ “Smartcar” аппликэйшн, Smartcar.mn цахим хуудас.
- ✓ Egolomt.mn системийн “Интернэт банк”-аар, “Golomt bank” аппликэйшн, “SocilalPay” аппликэйшнээр, “Голомт” банкны салбар дээр биеэр очиж төлбөр төлөх.
- ✓ “Гялс банк” аппликэйшн, Statebank.mn сайтын “Гялс цахим банк”-аар, мөн Төрийн банкны салбар дээр биеэр очиж төлбөр төлөх.

- ✓ “Gerege” аппликэйшнээр, “Гэрэгэ киоск” машинаар дамжуулан биеэр очиж төлбөр төлөх
- ✓ Худалдаа хөгжлийн банкны салбар төвүүдээр өөрийн биеэр очиж төлбөр төлөх
- ✓ Ebarimt.mn

Хүснэгт №6. Торгуулийн орлогыг төлбөрийн системээр дамжуулан төлсөн мэдээлэл/ тоогоор/

	Торгуулийн тоо	E-mongolia.mn	Smartcar.mn	Гэрэгэ киоск”	Ebarimt.mn	Арилжааны банк	бусад аппликэйшн	Албан хүсэлт
2023 оны торгууль	28,525.00							
2023 онд төлсөн торгууль	6,923.00	964.00	830.00	1,578.00	88.00	3,417.00	39.00	7.00
2024 онд төлсөн торгууль	11,168.00	2,605.00	1,079.00	1,881.00	8.00	5,406.00	167.00	22.00
2025 онд төлсөн торгууль	3,509.00	1,292.00	286.00	682.00	14.00	1,171.00	63.00	1.00
Төлөөгүй торгууль	6925.00							
2024 оны торгууль	28,693.00							
2024 онд төлсөн	13,785.00	4,286.00	2,125.00	1,929.00	7.00	5,206.00	231.00	1.00
2025 онд төлсөн торгууль	6,555.00	2,078.00	897.00	1,230.00	36.00	2,188.00	123.00	3.00
Төлөөгүй торгууль	8,353.00							
Нийт төлсөн торгууль	41,940.00	11,225.00	5,217.00	7,300.00	153.00	17,388.00	623.00	34.00
Нийт төлөөгүй торгууль	15,278.00							

Аймгийн Цагдаагийн газраас бэлэн бусаар 2023 онд 28,525 торгууль ногдуулснаас 24.3 хувь нь буюу 6,923 торгууль төлөгдсөн бол 2024 онд 28,693 торгууль ногдуулснаас 48 хувь нь буюу 13,785 торгууль төлөгдсөн байна. Торгуулийн орлогын төлөлт нь 2023 онд 24.3 хувьтай байсан бол 2024 онд 48 хувь болж нэмэгдсэн эерэг нөлөөг үзүүлж байна.

Дээрх хүснэгтээс харахад иргэд аймгийн Цагдаагийн газраас ногдуулсан торгуулийн 42 хувийг Төрийн банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан төлж байгаагийн 87 хувийг Төрийн банк эзэлж байна. Эндээс харахад иргэд торгуулийн төлбөрийг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкаар төлөх сонирхолтой байгаа тул цаашид торгуулийн төлбөрийн системд арилжааны банкуудыг тоог нэмэх шаардлагатай байна.

Г.1.3. Аймгийн цагдаагийн газраас бусад эрх бүхий албан тушаалтантай байгууллагуудад торгуулийн орлого бүрдүүлэлтийн хяналтын систем байхгүй байна.

Аймгийн Цагдаагийн газар нь e-patrol системийн “Од” программаар торгуулийн орлогын бүрдүүлэлтэд бүрэн хяналт тавьж байна.

Г.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Г.2.1. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогоос 109.6 сая төгрөгийн торгуулийг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авсан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1.12 дахь заалтад “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах” гэж заасны дагуу тайлант хугацаанд 109.6 сая төгрөгийн торгуулийг барагдуулахаар шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна.

Шүүхийн байгууллагаас 2023-2024 онд 109.6 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлснээс 99.3 сая төгрөгийг бүрэн барагдуулж 10.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №7. Аймаг, сумдын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан жагсаалт, /сая төгрөг/

№	Нэр	Барагдаагүй		Барагдсан		Түдгэлзүүлсэн	
		Иргэний тоо	Зөрчлийн дүн	Иргэний тоо	Зөрчлийн дүн	Иргэний тоо	Зөрчлийн дүн
1	2023 он	112	26.8	110	26.1		
2	2023 оны эцсийн үлдэгдэл	2	0.7	0	0	0	0
3	2024 он	182	82.8	178	53.2	1	20.0
4	2024 оны эцсийн үлдэгдэл	3	10.3	0	0	0	0

Г.2.2. Аймгийн Төрийн аудитын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн бол бусад эрх бүхий байгууллагаас хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд байна", 4.1.37-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд байна", Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 -д "Аймгийн Засаг дарга аймгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайланд

хяналт тавих чиг үүрэгтэй”, 22.1.3-д “Сумын Засаг дарга сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайланд хяналт тавих чиг үүрэгтэй” гэж тус тус заасан байна.

Гэтэл аймаг, сумдын хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, зөрчил хянан шалгах эрх бүхий албан тушаалтантай байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023, 2024 оны орлого бүрдүүлэх үйл ажиллагаанд аймаг, сумдын Засаг дарга хяналт шалгалт хийгээгүй байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба нь хяналт тавих чиг үүрэгтэй боловч торгуулийн орлогын бүрдүүлэлтийг зөвхөн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлээр тайлагнаж байна. Аймгийн хэмжээнд торгуулийн ногдуулалт, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад хяналт тавих нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, хяналт сул байна. Харин торгуулийн орлогын зарцуулалтад анхан шатны баримтыг үндэслэн хяналт хэрэгжүүлж байгаа ч зарцуулсан төсвийн үр дүнд тавих хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

Засгийн газрын 2021 оны 134 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ыг баталж тус журамд заасны дагуу шийтгэлийн хуудас буюу үнэт цаасыг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс хариуцан бүртгэлээр олгож, тооцоо бодон, тайлагнах чиг үүрэгтэй байна. Эрх бүхий байгууллагын хувьд шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилж, шийтгэлийн хуудсыг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавих чиг үүрэгтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах 7 байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэстэй шийтгэлийн хуудасны тооцоог журамд заасан хугацаанд хийгээгүй, тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч нар шийтгэлийн хуудасны бүртгэл, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс эрх бүхий албан тушаалтантай тооцоо бодон тайлагнах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2⁴, 2.12⁵, 2.13⁶ 2.14⁷ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

- Завхан аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
- Гадаадын иргэн харьяатын газар
- Татварын газар

⁴ “Шийтгэлийн хуудсыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн хэвлүүлж, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгжид албан хүсэлтийн дагуу бүртгэлээр олгох бөгөөд түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт, зарцуулалтад тухайн эрх бүхий байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавина”.

⁵ “Эрх бүхий албан тушаалтан шийтгэлийн хуудасны тооцоог сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон шийтгэлийн хуудсыг олгох, тайлан, тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтантай хийж, тухайн байгууллагын ахлах нягтлан бодогч хяналт тавьж, улирал бүр удирдлагад танилцуулж баталгаажуулна.”

⁶ “Эрх бүхий байгууллага нь жил, хагас жил тутам аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгж эсхүл холбогдох дээд шатны байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хүргүүлж баталгаажуулна.”

⁷ “Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгж, эрх бүхий байгууллага нь жил бүр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог хийнэ

- Стандарт хэмжилзүйн хэлтэс
- Боловсролын газар
- АЗДТГ-ын Цэргийн штаб


Г.2.3. Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын удирдлага нь торгуулийн орлогын бүрдүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь торгуулийн орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг бөгөөд хууль, эрх зүйн зохицуулалтаар торгуулийн орлогыг зарцуулах эрх хэмжээ байхгүй байна.

Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын удирдлага нь шийтгэлийн хуудсыг олгон, зарцуулалтад нь хяналт хэрэгжүүлсэн боловч торгуулийн орлогын биелэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Г.2.4. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг дарга, ИТХ нь хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн байгууллагуудаар хяналт хэрэгжүүлэх ажлыг төлөвлөөгүй. Хөндлөнгийн байгууллагууд нь хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Торгуулийн орлогын төлөвлөлт нь бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн бөгөөд уг орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, төлөвлөжээ.
2. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хүүгийн орлогыг төлөвлөөгүй бол сумдын Засаг дарга нар Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг салгаж төлөвлөөгүй байна.
3. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэдэггүй, 2023, 2024 онуудад торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолоогүй байна.
4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь харилцан уялдаатай байгаа хэдий ч зарим хууль, журмын тодорхойгүй заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.
5. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж, хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж байна.
6. Эрх бүхий албан тушаалтнууд ногдуулсан торгуулийн хэрэгжилтэд анхаарч ажиллаагүйгээс тайлант хугацаанд онд 383.6 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.
7. Аймгийн Засаг даргын 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан 3,225.0 сая төгрөгийн татварын орлогыг хүүгийн орлогоор тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3-ийг зөрчжээ.
8. Тайлант хугацаанд 13 сумын Засаг дарга Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүү 158.8 сая төгрөгийг хүү торгуулийн орлогоор, 11 сумын Засаг дарга Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүү 421.0 сая төгрөгийг бусад орлогоор тайлагнасан байгаа
9. Аймгийн болон 14 сумын ИТХ нь хүү торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 221.4 сая төгрөгийг, 2024 онд 297.5 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.
10. Аймаг, сумдын ИТХ торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилахдаа өмнөх жилийн торгуулийн орлогын гүйцэтгэлийг харгалзаагүй, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасныг мөрдөж ажиллаагүй байна.
11. Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зориулалтын дагуу хуваарилсан, сумдын ГХУСАЗСЗ нь тайлант хугацааны зардлын хуваарилалт, төлөвлөгөө, тайланг Аймгийн ГХУСАЗСЗ-д ирүүлээгүй тул дүгнэх боломжгүй байна.
12. Аймгийн ГХУСАЗСЗ нь тайлант хугацаанд нийт хуваарилагдсан хөрөнгийн 97.7 хувийг зориулалтын дагуу зарцуулсан, сумдын ГХУСАЗСЗ тайлан мэдээгээ ирүүлээгүй тул тодорхойлох боломжгүй байна.

- 13.Аймгийн ГХУСАЗЗ нь хүү, торгуулийн орлогын зарцуулалтын үр дүн, тайланг нэгтгэж иргэд олон нийтэд мэдээлээгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан иргэдийн тоо нь аймгийн нийт хүн амтай харьцуулахад хангалттай бус байна.
- 14.Аймгийн Төрийн аудитын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн бол бусад эрх бүхий байгууллагаас хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.
- 15.Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба нь хяналт тавих чиг үүрэгтэй боловч торгуулийн орлогын бүрдүүлэлтийг зөвхөн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлээр тайлагнаж байна. Аймгийн хэмжээнд торгуулийн ногдуулалт, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад хяналт тавих нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, хяналт сул байна.
- 16.Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын удирдлага нь эрх бүхий албан тушаалтнуудад шийтгэлийн хуудсыг бүртгэлээр олгон, зарцуулалтыг хянаж байгаа ч торгуулийн орлогын биелэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.
- 17.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй, иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.
- 18.Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогоос 109.6 сая төгрөгийн торгуулийг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авсан байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН 2023-2024 ОНД НОГДУУЛСАН 383.6 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫН СИСТЕМ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

Аудитаар нийт 4,105.4 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 3,225.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 880.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад хугацаатай 27 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН ДАРГА НАРТ:

1. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлтөд хяналт тавьж ажиллах
2. Торгуулийн орлогоос гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, авто замын санд хууль, журмын дагуу хөрөнгө хуваарилах
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журамд заасан зориулалт, хувь хэмжээнд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах
4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас орон нутагт ажиллаж байгаа бусад эрх бүхий албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад хуваарилах, зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоох
5. Хүү торгуулийн орлогын зарцуулалтын үр дүн, тайланг нэгтгэж иргэд олон нийтэд хүргэх, хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн байгууллагуудаар хяналт хийлгэх

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР ТАНАА:

1. Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцон төлөвлөх, төсвийн байгууллага болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүг төлөвлөх
2. Торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох, салбарын зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй эрх бүхий албан тушаалтнуудтай байгууллагуудын удирдлагуудад ажил сайжруулах чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцох, эрх бүхий албан тушаалтнуудад Зөрчлийн тухай хуулийг хэрэгжилтийг сайжруулах талаар нэгдсэн сургалт зохион байгуулах
3. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогын судалгааг гарган, барагдуулах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллах
4. Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах үүргийг аймгийн ЗДТГ-ын санхүү, Төрийн сангийн хэлтэс, Сумын Засаг дарга нарт хүргүүлэн, биелэлтийг тооцох, торгуулийн дансанд үйлчилгээний төлбөр төвлөрдөг зөрчлийг арилгах
5. Эрх бүхий албан тушаалтнууд бүхий байгууллагуудын хооронд торгуулийн орлогын мэдээллийн нэгдсэн сан бий болгох
6. Аймаг, сумдын хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, зөрчил хянан шалгах эрх бүхий албан тушаалтантай байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орлого бүрдүүлэх үйл ажиллагаанд нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх

7. Торгуулийн ногдуулалт, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад хяналт тавих нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, улсын төсөвт төвлөрүүлж байгаа торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулах
8. Хүү торгуулийн орлогын зарцуулалтын үр дүн, тайланг нэгтгэж иргэд олон нийтэд хүргэх, хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн байгууллагуудаар хяналт хийлгэх

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг салгаж төлөвлөх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүг төлөвлөх
2. Торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох, салбарын зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй эрх бүхий албан тушаалтнуудтай байгууллагуудын удирдлагуудад ажил сайжруулах чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцох
3. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогын судалгааг гарган, барагдуулах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллах
4. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, зөрчил хянан шалгах эрх бүхий албан тушаалтантай байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орлого бүрдүүлэх үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх
5. Улсын төсөвт төвлөрүүлж байгаа торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСТ:

1. Шийтгэлийн хуудас /үнэт цаас/-ны бүртгэл, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлж, тооцоог журамд заасан хугацаанд хийн, тайлагнаж хэвших
2. Торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын орлогын биелэлтэд хяналт хэрэгжүүлэхэд ойлгомжтой байхаар дансны хуваарилалтыг хийх
3. Торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, торгуулийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох
4. Хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах торгуулийн дансанд үйлчилгээний төлбөр төвлөрдөг зөрчлийг арилгах

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНТАЙ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ :

1. Улсын төсөвт төвлөрүүлж байгаа торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулах
2. Шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилж, шийтгэлийн хуудсыг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт хамгаалалт, зарцуулалт, торгуулийн орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавих
3. Эрх бүхий албан тушаалтнуудад шийтгэлийн хуудасны тооцоог журамд заасан хугацаанд хийх, салбарын зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, ажил сайжруулах чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцох
4. Эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогын судалгааг гарган, барагдуулах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авч ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД
ТУСГУУЛАХААР УЛАМЖЛАХ САНАЛ:**

1. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий зарим албан тушаалтнуудын салбарын хэмжээнд дагаж мөрддөг дүрэм, журамд өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн шатны арга хэмжээ авах зохицуулалт байхгүй байгаад анхаарч дараагийн шатны арга хэмжээ буюу торгох, хариуцлага тооцох хууль, эрх зүйн зохицуулалтыг нэгдсэн байдлаар тусгах,
2. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад торгуулийн орлогын тодорхой хувийг зарцуулах талаар хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад уламжлах
3. Монгол банк, Гаалийн байгууллага, Эрүүл мэндийн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагуудаас ногдуулсан торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн төсвийн эх үүсвэрт төвлөрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагад хүргүүлэх
4. Захиргааны ерөнхий хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт “Захиргааны шийдвэрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд захиргааны байгууллага хуульд заасан журмын дагуу албадлага хэрэглэнэ” гэж заасанд нийцүүлэн албадлагыг ямар хэлбэрээр явуулах талаар холбогдох хууль тогтоомжид нарийвчилсан зохицуулалтыг тусгуулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-2211

И-мэйл: zavkhan@itkh.za.gov.mn

2025. 07. 25 № 1/150
танай 2025. 04. 24 -ны № 555 Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт,
зарцуулалт” сэдэвт аудитын тайлангийн төсөлд
оруулах саналгүй болно.

ДАРГА  Б.САНЖСҮРЭН



ТБАГУТУГ
0470198 0922020027 9039295

8109006223

D:/Тоот А5 2021/



МОНГОЛ УЛС
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025.07.25 № 2/710
танай _____ -ны № _____ т

ЗАВХАН АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд саналгүй болно.

ОРЛОГЧ

Д.УУЖИМСАНАА